



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/52

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1205 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дүрэм”-ийн 7.1.1 дэх заалт, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2021 оны А/98 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын “Дотоод аудитын 2026 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнахыг Дотоод аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Оюун-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Анар)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.БАТЦЭЦЭГ

1725010146

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2026 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн А/52 дугаар тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР
ДОТООД АУДИТЫН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 оны 03 дугаар сарын 11

Улаанбаатар хот

№	Арга хэмжээ	Төсөв (мян.төг)	Гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Дотоод аудит хийх хугацаа		Хамаарах нэгж, албан хаагч
					Хагас жил	Жилийн эцэс	
1	2	3	4	5	6	7	8
Зорилго 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн гүйцэтгэл, газрын даргын тушаалаар баталсан дүрэм, журмын хэрэгжилт болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж буй байдалд дотоод аудит хийж, хэрэгжилт үр дүн, хариуцлагыг дээшлүүлэх талаар дүгнэлт, зөвлөмж өгөх удирдлагыг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж, үр дүнг газрын даргын өмнө хариуцна.							
Зорилт 1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал, газрын даргын тушаалаар батаслан дүрэм, журмын хэрэгжилтэд дотоод аудит хийж холбогдох дүрэм, журам аргачлалыг хэрэгжүүлж ажиллана.							
1.	Газрын даргаас үүрэг болгосны дагуу тодорхой чиглэлээр төлөвлөгөөт бус дотоод аудитыг зохион байгуулах.	-	Аудит хийсэн тоо	Удирдлагыг үнэн, зөв мэдээллээр хангаж, холбогдох албан хаагчид зөвлөгөө өгч дэмжлэг үзүүлсэн байна.	-	07-12 сар	Дотоод аудитор
2.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд дотоод аудит хийх.	-	Аудит хийсэн тоо	Удирдлагыг үнэн, зөв мэдээллээр хангаж, холбогдох албан хаагчид зөвлөгөө өгч дэмжлэг үзүүлсэн байна.	06-09 сар	06-09 сар	Ажлын хэсэг

1	2	3	4	5	6	7	8
3.	Газрын даргын тушаалаар батлагдсан дүрэм, журмын хэрэгжилтэд дотоод аудит хийх.		Дүрэм журмын тоо	Удирдлагыг үнэн, зөв мэдээллээр хангаж, холбогдох албан хаагчид зөвлөгөө өгч дэмжлэг үзүүлсэн байна.	-	09-11 сар	Дотоод аудитор
Зорилт 2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж буй байдалд дотоод аудит хийж, хэрэгжилт үр дүн, хариуцлагыг дээшлүүлэх талаар дүгнэлт, зөвлөмж гарган удирдлагыг мэдээллээр хангаж ажиллах.							
4.	Тус газарт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж буй байдалд	-	Дотоод аудит хийсэн төсөл, арга хэмжээний тоо	Үр дүн, хариуцлагыг дээшлүүлэх талаар дүгнэлт, зөвлөмж гарган Удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан байна.	01-06 сар	07-12 сар	Дотоод аудитор
5.	Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллах.	-	1.НХААГ-ЫН 2025 оны жилийн эцсийн аудитлагдсан тайланд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллах. 2.Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар холбогдох албан хаагчдад дэмжлэг	Төрийн аудитын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн биелэлт сайжирч, заасан хугацаанд зөвлөмжийн хэрэгжүүлэн, алдаа дутагдал гарах эрсдэлийг бууруулан дэмжлэг үзүүлсэн байна.	-	07-12 сар	Дотоод аудитор Холбогдох албан хаагчид
Зорилт 3. Төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн стандарт, хэрэгжилт, нээлттэй байдалд дотоод аудит хийнэ.							
6.	Төсөв, санхүү нягтлан бодох бүртгэлийн хэрэгжилтэд дотоод аудит хийх.	-	Аудит хийсэн тоо	Санхүүгийн үйл ажиллагааг хууль, журмын дагуу хөтлөн явуулахад дэмжлэг үзүүлсэн байна.	-	06-12 сар	Дотоод аудитор

1	2	3	4	5	6	7	8
7.	Ил тод байдлын хэрэгжилтэд аудит хийх.	-	Аудит хийсэн тоо	Шилэн данс болон байгууллагын цахим хуудаст аудит хийсэн байна.	-	06-12 сар	Дотоод аудитор

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
 ДОТООД АУДИТОРЫН АЛБАН
 ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Б.ОЮУН-ЭРДЭНЭ